



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umngovi@audit.gov.mn

2023.03.24 № 287

танай _____-ны № _____-т

**БАЯН-ОВОО СУМЫН ЭКО БАЯН-
ОВОО ХОТ ТОХИЖИЛТ ОНӨААТҮГ-Т**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд
заасан бүрэн эрхийн хүрээнд 2022 оны санхүүгийн
тайлан, тодруулгад хийсэн аудитын тайлан,
дүгнэлтийг хүргүүлж байна.

Хавсралт 14 хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц. ӨСӨХБАЯР



D/Явсан Бичиг/2023он/2023-03-24.Doc

016030198



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.03.15 № 238

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баян-Овоо сумын Эко баян-овоо хот тохижилт ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Баян-Овоо сумын Эко баян-овоо хот тохижилт ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Завсрын аудитын зөвлөмжөөр Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, бизнес төлөвлөгөөг батлуулан, аж ахуйн нэгж байгууллагын "Leader" программаар санхүүгийн тайланг гаргасан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд 51.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 54.0 сая төгрөгийг зардал гарган, 2.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

016020331

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын Эко баян-овоо хот тохижилт ОНӨААТҮГ-н 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ӨМА-2023/49/НА-СТА-ОНА**

Цахим хуудас:
www.Umnu.govi@audit.mn

Өмнөговь аймаг
2023 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Аудитор: Т.Будсүрэн
Утас: 70533552 Цахим хаяг: budsurent@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	6
3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....	6
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	6
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	7
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	7
4. Аудитын тайлан.....	8
4.1 Ерөнхий зүйл	8
4.2 Материаллаг байдал	8
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	8
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	8
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	9
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	10
5. Аудитын илрүүлэлт.....	10
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон Нутгийн Өмчит Аж Ахуйн Тооцоот Үйлдвэрийн Газар



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.03.15 № 238
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баян-Овоо сумын Эко баян-овоо хот тохижилт ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Баян-Овоо сумын Эко баян-овоо хот тохижилт ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Завсрын аудитын зөвлөмжөөр Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, бизнес төлөвлөгөөг батлуулан, аж ахуйн нэгж байгууллагын "Leader" программаар санхүүгийн тайланг гаргасан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд 51.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 54.0 сая төгрөгийг зардал гарган, 2.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

016020331

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

№	БАЛАНСЫН ЗҮЙЛ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
	Б	1	2
1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3,731,824.66	782,789.14
2	Дансны авлага	9,552,670.00	4,012,534.32
3	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	510,454.54	-
4	Эргэлтийн хөрөнгийн дүн	13,794,949.20	4,795,323.46
5	Үндсэн хөрөнгө	-	188,604,389.80
6	Бусад үндсэн хөрөнгө	900,000.00	1,310,000.00
7	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	900,000.00	189,914,389.80
8	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	14,694,949.20	194,709,713.26
9	Орлогын татварын өглөг	1,467,894.92	50.00
10	НӨАТ-ын өглөг	-	1,274,197.95
11	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,467,894.92	1,274,247.95
12	Бусад урт хугацааны өглөг		189,006,068.80
13	Урт хугацааны өр төлбөрийн дүн	-	189,006,068.80
14	Өр төлбөрийн нийт дүн	1,467,894.92	190,280,316.75
15	Өмч-төрийн	16,000.00	16,000.00
16	Хуримтлагдсан ашиг	13,211,054.28	4,413,396.51
17	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	14,694,949.20	4,429,396.51
18	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	14,694,949.20	194,709,713.26

2.2 Аудит хийсэн ор дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлан он
1	Борлуулалтын орлого/цэвэр/	23,238,699.04	35,910,343.39
2	Борлуулалтын өртөг	58,033,534.13	38,560,488.89
3	Нийт ашиг	(34,794,835.09)	(2,650,145.50)
4	Бусад орлого	55,000,000.00	7,179,092.00
5	Ерөнхий ба удирдлагын зардал	5,526,215.71	13,326,604.27
6	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	14,678,949.20	(8,797,657.77)
7	Орлогын татварын зардал	(1,467,894.92)	
8	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	13,211,054.28	8,797,657.77
9	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	13,211,054.28	(8,797,657.77)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлан он
1	Мөнгөн орлогын дүн/+/-	70,313,563.00	51,055,141.10
2	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	70,313,563.00	51,055,141.10
3	Мөнгөн зарлагын дүн /-/-	66,597,738.34	54,004,176.62
4	Ажилчдад төлсөн	6,265,119.00	22,045,907.00
5	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,969,608.66	6,806,543.96
6	Бараа материал худалдан авахад төлсөн	55,984,278.00	13,602,500.00
7	Ашиглалтын зардалд төлсөн	146,990.23	1,597,484.69
8	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	3,740,420.00
9	Татварын байгууллагад төлсөн	2,231,742.45	5,756,195.97

10	Бусад мөнгөн зарлага	-	455,125.00
11	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,715,824.66	(2,949,035.52)
12	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	3,715,824.66	(2,949,035.52)
13	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16,000.00	3,731,824.66
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,731,824.66	782,789.14

2.4 Аудит хийсэн цэвэр өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	16,000.00	-	16,000.00
2	Залруулсан үлдэгдэл	16,000.00	13,211,054.28	13,227,054.28
3	Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал/		(8,797,657.77)	(8,797,657.77)
4	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	16,000.00	4,413,396.51	4,429,396.51

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Дугаар	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Бараа бүтээгдэхүүн борлуулсны орлого	-	51,055,141.10
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	54,004,176.62
3	Ажилчдад төлсөн	-	22,045,907.00
4	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	6,806,543.96
5	Бараа материалын худалдан авахад төлсөн	-	13,602,500.00
6	Ашиглалтын зардалд төлсөн	-	1,597,484.69
7	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	3,740,420.00
8	Татварын байгууллагад төлсөн	-	5,756,195.97
9	Бусад мөнгөн зардал	-	455,125.00

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын зорилго нь Орон нутгийн гол хөгжлийн хөшүүрэг болсон цэвэр ус түгээх, бохир усыг татан зайлуулах, хог хаягдлыг ачиж тээвэрлэх, нийтийн ахуйн үйлчилгээг хүртээмжтэй явуулж, хэрэглэгчдийн таатай тухтай орчныг бүрдүүлэн тасралтгүй найдвартай ханган үйлчилж ажиллах. Хэрэглэгчдийн эрх ашгийг хангаж өөртөө татан авах нь манай байгууллагын эрхэм зорилго.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” гэж заасны дагуу дотоод

хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулаагүй, дотооддоо хяналт шалгалтын баг зохион байгуулаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өмнөговь аймгийн Баян-овоо сумын эко баян-овоо хот тохижилт ОНӨААТҮГ-н 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өмнөговь аймгийн Баян-овоо сумын эко баян-овоо хот тохижилт ОНӨААТҮГ-н 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалаар баталсан “Аж ахуй нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 180.0 сая төгрөгөөр буюу 1225 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,731,824.66	782,789.14	-2,949,065.52
Бараа материал	0	0	0
Үндсэн хөрөнгө	0	188,604,389.80	188,604,389.80
Нийт хөрөнгө	14,694,949.20	194,709,713.26	180,014,764.06
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	14,694,949.20	4,429,396.51	-10,265,552.69
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	14,694,949.20	194,709,713.26	180,014,764.06

Дээрх хүснэгтээс харахад үндсэн хөрөнгө өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан байна. Үндсэн хөрөнгө 188.6 сая төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 10.8 сая төгрөгийн ус цэвэршүүлэх төхөөрөмж, аймгийн иргэдийн төлөөлөгчийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 9/69 тоот захирамжаар тус сумын соёлын төвөөс 34.5 сая төгрөгийн фургон машин балансаас балансыг шилжүүлэн бүртгэсэн. Говийн оюу хөгжлийг дэмжих сангаас 5.5 сая төгрөгийн хогны талбайг тус тус хүлээн авч үндсэн хөрөнгөнд бүртгэсэн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дүгээр зүйлийн 1.2-д заасны дагуу “Эко баян-овоо хот тохижилт” ОНӨААТҮГ-ын захирал Э.Мэндсайхан нь зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангаж эдийн засгийн үр дүн, хүрэх түвшинг батлуулсан байна.

Гүйцэтгэлээр борлуулалтын орлогоор 51.1 сая төгрөг нийт 51.1 сая төгрөгийг бүрдүүлж, 54.4 сая төгрөгийг зарцуулан, 2.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

4.АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өмнөговь аймгийн Баян-овоо сумын эко баян-овоо хот тохижилт ОНӨААТҮГ-н 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх ТӨҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Т.Будсүрэн гүйцэтгэж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Ж.Болормаа, чанарын хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Өмнөговь аймгийн Баян-овоо сумын эко баян-овоо хот тохижилт ОНӨААТҮГ-н 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дүгээр сарын 12-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 63.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 0.6 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 158 мэдээлэл байршуулахаас 30 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"-д заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг үнэн зөв, тогтоосон хугацаанд тогтмол тусгаж байх зөвлөмж өгсөн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар Баян-овоо сумын эко баян-овоо хот тохижилт ОНӨААТҮГ-ын цалингийн зардал, борлуулалтын орлого, удирдлагын зардал, борлуулсан бүтээгдэхүүний өртөг, цалингийн түүврээр илрүүлсэн илрүүлэлт, бизнес төлөвлөгөө, бодлогын баримт бичиг, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд горим сорил хэрэгжүүлэн 8 зөвлөмжийн заалтыг асуудлын бүртгэлд тусгасан. Асуудлын бүртгэлээр өгсөн зөвлөмжийн биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж үр дүнг аудитын тайланд тусгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1,2 дугаар хавсралтын дагуу “Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгээгүй, си ти эс программ нь аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд уялдаагүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй, бизнес төлөвлөгөө гаргаж эдийн засгийн үр ашиг тооцож ажиллаагүй, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлын цалин болон ажилчдын цалинг ТҮ гэсэн цалингийн шатлалаар цалинжуулсан, борлуулсан бүтээгдэхүүний өртгийн бүртгэлийг орлогын тайлантай тус тус зөрүүтэй тусгасан байна. Шилэн дансны цахим системд 118 мэдээлэл байршуулахаас 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	Байхгүй.				
Албан шаардлага	Байхгүй.				
Зөвлөмж	8	75,337,391.65	8	75,337,391.65	100
Нийт дүн	8	75,337,391.65	8	75,337,391.65	100

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2 алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөм өглөө.

5.1 Төлбөрийн акт:

Аудитаар төлбөрийн акт гараагүй байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага гараагүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өглөгтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт-1: Байгууллагад төлөх 1,274,247.95 төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтыг хэрэгжүүлэх

2. Шилэн данстай холбоотой асуудал:

Илрүүлэлт-2: Шилэн дансны цахим хуудсанд 158 мэдээлэл байршуулахаас 30 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Мэдээллийг тогтоосон хугацаанд, шуурхай мэдээлдэг байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 10 дугаар сарын 02 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байхгүй.												
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	0					1	0				
Дүн	1	0					1	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 158 мэдээлэл байршуулахаас 30 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан	1	0					1	0
Нийт дүн	1	0					1	0